

БАТЛАВ:  
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ  
БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад “Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах”, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтад “нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлага бүхий 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

**Хоёр. Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд үүнд Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагыг тусгана.

Төсвийн гүйцэтгэлийн тайландаа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгана. Үүнд:

1. Тухайн жилийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүн, хөтөлбөр, төсвийн захирагч болон хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр гаргасан тайлан;
2. Татварын зарлагыг хуулийн этгээд болон салбар бүрээр нь холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт гаргасан тайлан;
3. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан;
4. Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт болон тасарсан бол шалтгаан);
5. Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан болон түүний танилцуулга зэрэг болно.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвийн 2023 оны орлого, зарлагын нийт хэмжээ батлагдаж, төсвийн ашиг, алдагдлыг тодорхойлох боломжтой болно.

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, тогтоолыг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.